

Гарчиг

Бичмэл мэдээлэл

- I. Төсвийн орлого
- II. Төсвийн зарлага
- III. Банк
- IV. Бүртгэлтэй ажилгүйчүүд
- V. Ажлын байрны зуучлал
- VI. Нийгмийн халамж
- VII. Нийгмийн даатгал
- VIII. Эрүүл мэнд
- IX. Хэрэглээний барааны үйлчилгээний үнэ, үнийн индекс
- X. Хөдөө аж ахуй
- XI. Аж үйлдвэр
- XII. Гэмт хэрэг
- XIII. Байгаль орчин
- XIV. Гамшиг, осол, гал түймрийн мэдээ

Хүснэгтэн мэдээлэл

- I. Орон нутгийн төсвийн орлогын мэдээлэл
- II. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /Сумаар/
- III. Орон нутгийн төсвийн зарлагын дүн
- IV. Дундговь аймаг дахь банкны салбарын мэдээлэл
- V. Аймгийн ажил хайгч иргэдийн мэдээлэл
- VI. Ажлын байрны зуучлал
- VII. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, тэтгэврийн санхүүжилт
- VIII. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага
- IX. Нийгмийн даатгал заавал даатгуулагчийн тоо, тэтгэврийн хэмжээ
- X. Хүн амын ердийн хөдөлгөөн, хүүхдийн эндэгдэл
- XI. Эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
- XII. Гол нэрийн бүтээгдэхүүний үнэ
- XIII. Хэрэглээний үнийн индекс
- XIV. ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ
- XV. Төл бойжилтын мэдээ
- XVI. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн
- XVII. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт
- XVIII. Нийгмийн халамжийн сангийн мэдээ
- XIX. Гэмт хэргийн мэдээ
- XX. Гамшиг, осол, гал түймрийн мэдээ

Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2020 оны 5-р сарын байдлаар)

I.Төсвийн орлого



Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2020 оны 5-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 85.3 хувьтай буюу 3 324.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 92.4 хувьтай буюу 713.4 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 4 083.3 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 86.5 хувьтай байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 42 432.5 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 96.6 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 6 617.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 13 294.5 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1 347.6 сая төгрөг, хандив тусламжаас 98.7 сая төгрөг, төсвөөс санхүүжих 13 064.3 сая төгрөг, аймгаас авсан татаас 4 685.1 сая төгрөг, нийт 39 107.6 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогынхоо төлөвлөгөөг Гурвансайхан, Хулд, Эрдэнэдалай сумд 4.1-11.1 хувиар буюу 4.6-19.1 сая төгрөгөөр тасалдуулсан бол бусад бүх сумд 0.1-48.8 хувиар буюу 0.1-45.3 сая төгрөгөөр төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн байна.

II.Төсвийн зарлага



2020 оны 5 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 22 595.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.5 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 10 937.6 сая төгрөг болж нийт зардлын 48.5 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 17.7 хувиар өсч 1 357.6 сая төгрөг болсон байна. Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас 80.3

хувь, хөрөнгийн зардал 60.5 хувь, хангамжийн бараа материалын зардал 1.1 хувиар тус тус өссөн бол бусад бүх зардал 3-70.6 хувиар буурсан байна.

III.Банк



Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өсч, 112 056.5 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1 452.3 сая төгрөг, чанаргүй зээл 1 342.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 94.2 хувиар, чанаргүй зээл 13.0 хувиар тус тус өссөн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 2.5 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 12.0 хувиар өсч, 73 912.8 сая төгрөг болсон ба мөн нийт харилцахын үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 35.6 хувиар өсч 21 283.2 сая төгрөг болов.

IV.Бүртгэлтэй ажилгүйчүүд



2020 оны 5 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 475 хүн бүртгэгдсэн нь өмнөх сартай харьцуулахад 31.3 хувиар өссөн байна. Нийт ажилгүйчүүдийн 48.6 хувь буюу 231 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 147 ажил хайгч иргэн ногдож байхад Цагаандэлгэр 235, Говь-Угтаал 217, Өндөршил 341, Хулд 247, Луус 188, Гурвансайхан 224, Дэлгэрхангай 177, Сайхан-Овоо 219, Баянжаргалан 175, Эрдэнэдалай 177 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.

V. Ажлын байрны зуучлал



ХХҮГазрын 2020 оны 5 сарын мэдээгээр нийт 208 хүн ажлын байранд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 68 хүнээр өссөн байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд ХАА, ан агнуур, ойн аж ахуйн салбарт 13.9 хувь, боловсруулах үйлдвэрт 0.5 хувь, цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт 0.5 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 8.2 хувь, боловсролын салбарт 6.3 хувь, үйлчилгээний бусад салбарт 48.6 хувь, хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 2.9 хувь,

төрийн удирдлага ба батлах хамгаалах үйл ажиллагааны салбарт 14.9 хувь, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт 0.5 хувь, урлаг, үзвэр, тоглоом наадмын салбарт 2.4 хувь, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарт 0.5 хувь, бөөний ба жижиглэнгийн худалдааны салбарт 1.0 хувь нь зуучлагдсан байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 118 нь буюу 56.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

VI. Нийгмийн халамж



2020 оны 5 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 16109 хүнд 2696.9 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна. Нийт тэтгэвэр тэтгэмж авагчдын 21 хувь буюу 3389 нь 0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүд болон олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх, жирэмсэн эмэгтэйчүүдэд 192.6 сая төгрөг, 10.7 хувь буюу 1726 иргэнд нийгмийн халамжийн тэтгэмжийг 626.4 сая төгрөг, 4,8 хувь буюу 777 иргэнд халамжийн тэтгэврийг 856.8 сая төгрөг, 1,3 хувь буюу 207 иргэнд бусад төрлийн тусламж үйлчилгээнд 49,8 сая, 27,5 хувь буюу 4464 иргэнд алдарт эхийн одонгийн мөнгөн тусламжийг 599.7 сая төгрөг, 15,5 хувь буюу 2495 нь насны хишигт 223.7 сая төгрөг, 18,9 хувь 3051 иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 147.9 сая төгрөгийг зарцуулжээ.

VII. Нийгмийн даатгал



Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 5 сарын байдлаар 16405.3 сая төгрөг, зарлага 14060.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 4994.1 сая төгрөгөөр буюу 43.8 хувиар, зарлага 138.6 сая төгрөг буюу 1 хувиар тус тус өсчээ.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2020 оны 5 сарын байдлаар 9225 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2014 хүн буюу 21.8 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 3809 хүн буюу 41.3 хувь нь төсөвт байгууллагаас, 3402 хүн буюу 36.8 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж ахуй нэгж байгууллага даатгуулагч, төсөвт байгууллагын даатгуулагч өсч, сайн дурын даатгуулагч буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2020 оны 5 сарын байдлаар 13873.0 сая төг болж, үүний 84.1 хувийг өндөр настны, 10 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 2.7 хувийг тэжээгчээ алдсаны, 3.2 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны 5 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч хүн 7463 байна. Нийт тэтгэвэр авагчдын 83.1 хувь буюу 6206 хүн өндөр насны, 11.8 хувь буюу 881 хүн тахир дутуугийн, 3.2 хувь буюу 237 хүн тэжээгчээ алдсаны, 1.8 хувь буюу 139 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Энэ оны 5 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 1043, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 27, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 72 хүн байна.

5 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 11054 байгаагийн 70.4 хувь буюу 7788 төр хариуцах иргэд, 19.5 хувь буюу 2160 малчид, 2.8 хувь буюу 313 оюутан суралцагсад, 7.1 хувь нь буюу 793 аж ахуй нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн байна.

2020 оны 5 сарын байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 4880.3 сая төгрөг болж төлөвлөгөө 13.3 хувиар буюу 745.7 сая төгрөгөөр дутсан байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө бүх сумд 4.5-34.1 хувиар тасалдуулсан байна.

VIII. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2020 оны 5-р сарын байдлаар 388 эх төрсөн ба нийт 392 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 14 төрөлтөөр өссөн байна. Төрсөн эхчүүдийн 91.0 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ сарын байдлаар 0-5 насны хүүхдийн 3 эндэгдэл гарсан байна. Нас баралтын 95 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 8 тохиолдлоор буурчээ. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 22 буюу 23.2 хувийг эзэлж байна.

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 4571 эмчлүүлэгч хэвтэж, 4581 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 32368 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.1 байна. 2020

оны 5 сарын байдлаар 79965 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 29.2%, өвчний учир амбулаторийн үзлэг 49.4%, идэвхтэй хяналт 15.0%, гэрийн үзлэг 4.6%- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 33.8 хувь нь эрэгтэй, 66.2 хувь нь эмэгтэй хүн байна. Халдварт өвчний 131 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 28.2 болж өмнөх оны мөн үеэс 60 тохиолдол буюу 12.7 пунктээр буурсан байна

IX. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2020 оны 5-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2019 оны 5-р сартай харьцуулахад 6.0 хувиар өсжээ.

Хэрэглээний үнийн индекс 6.0 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 8.5 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 3.3 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 9.3 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 7.8 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 5.6 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 2.9 хувиар өссөн, тээврийн бүлэг 3.3 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

2020 оны 5 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлшний үнийг орууллаа.

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

№	Барааны нэр, төрөл	V/03	V/13	V/20	V/27
1	Гурил, 1-р зэрэг, кг	1560	1560	1560	1560
2	Хонины мах, кг	8700	9500	9500	9700
3	Үхрийн мах, кг	0	0	0	0
4	Ямааны ястай мах, кг	7500	8500	8500	8500
5	Элсэн чихэр, кг	2000	2000	2000	2000
6	Цагаан будаа, кг	2660	2660	2530	2530
7	Шингэн сүү, л	3000	3000	3000	3000
8	Ноолуурын үнэ 1 кг	50000	45000	42000	42000
9	Бензин А-80, 1литр	1490	1490	1490	1400
10	Бензин А-92, 1литр	1580	1580	1580	1490
11	Дизель түлш 1 литр	2240	2240	2240	2090

Х.Хөдөө аж ахуй



Аймгийн хэмжээгээр энэ оны 5 сарын байдлаар 939.2 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төл 99.1 хувь буюу 930.7 мянган төл бойжиж байна.

Аймгийн хэмжээнд энэ оны 6 сарын 1-ний байдлаар 7693 толгой мал хорогдоод байна.

XI. Аж үйлдвэр



Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2020 оны 5 сарын байдлаар 3 453.1 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 15.4 хувиар буурсан байна.

XII. Гэмт хэрэг



Дундговь аймаг дахь Цагдаагийн газар нь 2020 оны 05 дугаар сард иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 660 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 159 гомдол, мэдээллээр буюу 19.4 хувиар хүлээн авсан гомдол, мэдээллийн тоо буурсан байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 33 буюу 31.4 хувь нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 28 буюу 26.6 хувь нь хулгайлах гэмт хэрэг, 11 буюу 10.4 хувь нь

хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргүүд байгаа бөгөөд эдгээр гэмт хэргүүд нийт хэргийн 68.6 хувийг эзэлж байна.

Нийт гэмт хэргийн гаралт өсөхөд, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 83.3 хувь, хулгайлах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 12 хувь, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг өмнөх оны үеэс 11 дахин тус тус өссөн нь шууд нөлөөлсөн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 286.5 сая төгрөгийн хохирлын 114.9 сая төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлж, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 46.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 19.1 пунктээр өссөн. Тайлангийн хугацаанд 30 сая төгрөгний эд хөрөнгө битүүмжилсэн байна.

Гэмт хэргийн улмаас 104 иргэн хохирч, 34 хүн нас барж, 44 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хохирсон хүний тоо 0.9 хувиар, гэмтсэн хүн 62.9 хувиар өсч, нас барсан хүний тоо 25 хувиар буурсан байна.

Гэмт хэрэгт нийт 65 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 холбогдогчоор буюу 30 хувь өссөн.

Нийт гэмт хэрэгт холбогдогчийн 6 буюу 9.2 хувь нь эмэгтэй хүн, 18 хүртэлх насны холбогдогч байхгүй, 12 буюу 18.5 хувийг хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 12 дахин өсч, эмэгтэй холбогдогчийн тоо 25 хувь тус тус буурсан байна. 2020 он гарсаар 18 хүртэлх насны хүүхэд гэмт хэрэгт холбогдоогүй байна.

Гэмт хэргийн илрүүлэлтийн түвшин улсын хэмжээнд 34.6 хувьтай, Дундговь аймагт 55.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын түвшин 10.7 пунктээр, аймгийн түвшин 9.2 хувиар тус тус өссөн үзүүлэлт байна. Гэмт хэргийн илрүүлэлт улсын дунджаас 15.4 пунктээр дээгүүр байна.

Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 4 хэргээр буюу 44.4 хувиар буурч, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 25 бүртгэгдэж 10 хэргээр буюу 66.6 хувь, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 11 бүртгэгдэж 6 хэргээр буюу 2.2 дахин тус тус өсч, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг ижил түвшинд, насанд хүрээгүй хүн оролцсон хэрэг бүртгэгдээгүй байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 05 дугаар сард 7730 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэс 582 зөрчлөөр буюу 7 хувиар, 7746 зөрчлийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 572 зөрчлөөр буюу 6,9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчил гаргасан 7617 иргэнийг 242.2 мянган төгрөгөөр торгосон байна. Үүнээс тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэргээр 91 хүнийг торгон, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасаж, 37 хүнд баривчлах шийтгэл тус тус ногдуулсан байна.

Нийт 182 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 133 хүн буюу 42 хувиар буурсан байна.

Нийт эрүүлжүүлэгдсэн хүний 33 хувь нь гудамж талбайгаас, 58.8 хувь нь гэр, орон сууцнаас, 1.6 хувь нь байгууллага, аж ахуйн нэгжээс, 1.6 зочид буудлаас, 0,5 хувь нь үзвэр үйлчилгээний газраас, 4.4 хувь нь бусад газраас эрүүлжүүлэгдсэн байна.

XIII. Гамшиг осол, гал түймрийн мэдээ



Аймгийн Онцгой байдлын газраас ирсэн мэдээгээр 2020 оны эхний 5 сарын байдлаар нийт ирсэн дуудлага өмнөх оны мөн үеэс 3-аар буюу 13 хувиар өссөн бөгөөд эрэн хайх үйл ажиллагаа 25 хувиар буурсан байна. Мал амьтны гоц халдвар 5-аар буюу 83.3 хувиар өссөн, гал түймэр 16.7 хувиар буурсан бол орон нутгийн дуудлага 3-аар буюу 75 хувиар өссөн байна.

I. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, мянган төгрөгөөр

2020.6.10

Үзүүлэлт	мөр	2019 V	2020 V			20/19
			төл	гүйц	хувь	хувь
Нийт орлого /тусламжийн дүн/	1	18705246.3	43927364.5	42432492.3	96.6	226.8
А.УРСГАЛ ОРЛОГО	2	2777636.9	3858020.5	3292949.3	85.4	118.6
І.ТАТВАРЫН ОРЛОГО	3	1431834.0	1500784.0	1985290.5	132.3	138.7
1.1 Хүн амын орлогын албан татвар	4	1010214.0	966410.0	1505541.2	155.8	149.0
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар	5	1265576.9	1290000.0	1530935.0	118.7	121.0
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	6	-378123.9	-450000.0	-312345.2	-	-
1.2 үйл ажиллагааны орлого	7	78515.3	106410.0	253530.6	238.3	322.9
1.3 Хөрөнгө борлуулсаны	8	7590.6	20000.0	29545.8	-	389.2
1.5 Бусад татвар	9	36655.1	0.0	3875.0	-	10.6
2.Хөрөнгийн татвар/УХХболон буу/	10	35191.4	75990.0	29931.2	39.4	85.1
3. Авто тээврийн хэрэгслийн	11	200723.2	250200.0	172854.3	0.0	86.1
4. Бусад татвар	12	185705.4	208184.0	276963.8	133.0	149.1
4.1 Улсын тэмдэгтийн	13	59125.6	69460.0	66705.3	96.0	112.8
4.2 Ашигт малтмал нөөцийн	14	7978.8	3200	6767.1	-	84.8
4.3 Газрын төлбөр	15	42625.1	78480.0	117100.2	149.2	274.7
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	16	6666.7	54150.0	38023.0	70.2	570.3
4.6 Усны төлбөр	17	19931.8	2894.0	20320.2	-	101.9
4.6.Бусад	19	49377.4	0.0	28048.0	-	56.8
II.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20	1345802.9	2357236.5	1307658.8	55.5	101.6
2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого	21	836441.4	1935176.5	720124.4	37.2	86.1
2.2 Бусад нэр заагдаагүй	22	509361.5	422060.0	587534.4	139.2	115.3
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	23	47684.5	38750.0	31946.7	82.4	67.0
В.ТУСЛАМЖ ИЙН ОРЛОГО	24	15879924.9	40030594.0	39107596.3	97.7	246.3
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	25	5413657.6	7497651.3	6617411.5	88.3	122.2
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	26	9625577.5	12100956.5	13294538.4	109.9	138.1
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих	27	795643.3	2194639.4	1347606.6	61.4	169.4
Хандив тусламж	28	45046.5	144561.5	98668.2	68.3	-
Төсвөөс санхүүжих	29	0.0	13241906.3	13064323.1	98.7	-
Аймаг нийслэлээс авсан татаас	30	0.0	4850879.0	4685048.5	96.6	-
Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /	31	2825321.4	3896770.5	3324896.0	85.3	117.7
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	32	927961.2	772060.0	713410.2	92.4	76.9
Аймгийн нийт орлого	33	3753282.6	4668830.5	4038306.2	86.5	107.6

II.Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

Сумд	2020 I-V			2020 V сар		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Дэлгэрцогт	48250.0	67296.8	139.5	16090.0	28122.7	174.8
Дэрэн	58470.0	72000.8	123.1	13690.0	33735.6	246.4
Говь-Угтаал	256030.0	301352.1	117.7	41130.0	56432.4	137.2
Цагаандэлгэр	31900.0	47458.3	148.8	5630.0	20308.8	360.7
Баянжаргалан	79135.0	86968.1	109.9	21390.0	22161.2	103.6
Өндөршил	56810.0	79146.0	139.3	11150.0	34160.1	306.4
Гурвансайхан	171810.0	152667.8	88.9	34420.0	59780.3	173.7
Өлзийт	86595.0	86706.0	100.1	19070.0	42725.3	224.0
Хулд	100600.0	95989.9	95.4	19770.0	36074.6	182.5
Луус	57140.0	82881.6	145.1	9560.0	34373.1	359.6
Дэлгэрхангай	82450.0	103879.9	126.0	13770.0	29005.3	210.6
Сайхан-Овоо	49620.0	63189.9	127.3	8900.0	17389.4	195.4
Эрдэнэдалай	145980.0	140000.8	95.9	22560.0	59418.3	263.4
Сайнцагаан	373187.0	382158.3	102.4	152260.0	124023.8	81.5
Адаацаг	66400.0	83131.2	125.2	20025.0	29460.6	147.1
Дундговь	965330.0	1316871.2	136.4	84050.0	-129525.9	-154.1
Дүн	2629707.0	3161698.7	120.2	493465.0	497645.6	100.8

III.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2020.06.10

Зарлагын төрөл	2019 V	2020 V			2020 V /2019 V
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Орон нутгийн байгууллагын зарлагын дүн	16547562.1	33082493.5	22595288.5	68.3	136.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9290203.6	13418274.5	10937550.7	81.5	117.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1159704.4	1799618.1	1357008.9	81.5	117.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2277379.5	2670591	2189861.5	75.4	96.2
Хангамж бараа материалын зардал	291887.9	451631.4	295242.7	65.4	101.1
Норматив зардал	533973.2	369706.9	156735.4	42.4	29.4
Эд хогшил урсгал засварын зардал	148213.6	162713.6	109790.9	67.5	74.1
Томилолтын зардал	103381.1	41148.4	39247.1	95.4	38.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	408342.9	603174.8	395926.4	65.6	97.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1160973.4	1950591.3	518616.5	26.6	44.7
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	92603.7	166976.6	166976.6	100.0	180.3
Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.0	4872486.1	4685048.5	96.2	-
Бусад урсгал шилжүүлэг	556769	325387.2	190687.7	58.6	34.2
Хөрөнгийн зардал	524129.8	3832064.5	841053.0	62.2	160.5
Эргэж төлөгдөх зээл	0	2418129.1	711542.6	29.4	-

IV. ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ

2020.06.10

(Сая.төгрөг, тоогоор)

Үзүүлэлт		Үлдэгдэл		2019/2020 хувь	
		2019-V	2020-V		
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл		110888.8	112,056.5	101.1
	Үүнээс:	Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	747.9	1,452.3	194.2
		Чанаргүй зээлийн үлдэгдэл	1188.0	1,342.3	113.0
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл		15691.9	21,283.2	135.6
	Үүнээс:	Иргэдийн харилцахын үлдэгдэл	-	15,595.2	-
	Нийт хадгаламжийн үлдэгдэл		65998.3	73,912.8	112.0
	Үүнээс:	Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	-	73,874.6	-
		Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	19754.0	18,918.3	95.8
Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл		46244.3	54,994.5	118.9	
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо		-	34	-
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо		-	169	-
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)		-	20652	-
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)		-	85422	-
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)		-	33756	-
	Нийт АТМ-ны тоо		-	19	-
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо		-	40319	-

V. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2020.06.10

Сум	Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам	Тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд	Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд	Үүнээс эмэгтэй	Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд
Дэлгэрцогт	1178	10	13	3	110
Дэрэн	1474	20	17	4	115
Говь-Угтаал	1106	29	24	13	217
Цагаандэлгэр	723	23	17	6	235
Баянжаргалан	858	10	15	6	175
Өндөршил	1027	24	35	19	341
Гурвансайхан	1560	28	35	6	224
Өлзийт	1712	2	13	5	76
Хулд	1697	42	42	23	247
Луус	1331	21	25	9	188
Дэлгэрхангай	1581	24	28	14	177
Сайхан-Овоо	1508	31	33	19	219
Эрдэнэдалай	3954	2	70	47	177
Сайнцагаан	10649	78	93	49	87
Адаацаг	1958	18	15	8	77
Дүн	32316	362	475	231	147

VI. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2020 оны 05 сарын байдлаар

2020.06.10

Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	Үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	29.0	7.0	13.9
Уул уурхай олборлох үйлдвэр	0.0	0.0	0.0
Боловсруулах аж үйлдвэр	1.0	0.0	0.5
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	1.0	0.0	0.5
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	0.0	0.0	0.0
Барилга	0.0	0.0	0.0
Бөөний ба жижиглэн худалдаа	2.0	2.0	1.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1.0	1.0	0.5
Зочид буудал, зоогийн газар	0.0	0.0	0.0
Мэдээлэл холбоо	0.0	0.0	0.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.0	1.0	0.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	17.0	10.0	8.2
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	31.0	19.0	14.9
Боловсрол	13.0	10.0	6.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	6.0	3.0	2.9
Урлаг, үзвэр, тоглоом наадам	5.0	3.0	2.4
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	101.0	62.0	48.6
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0
Бүгд	208.0	118.0	100.0

VII. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВЭРИЙН САНХҮҮЖИЛТ

2020.06.10

мян.төг

Сумд	Н.Д.Шимтгэлийн орлого			Тэтгэвэрийн санхүүжилт		
	төл	гүйц	хувь	олгох	олгосон	хувь
Дэлгэрцогт	149584.1	120475.1	80.5	570560.9	570560.9	100.0
Дэрэн	145705.3	122878.9	84.3	624458.1	624458.1	100.0
Говь-Угтаал	189011.2	139077.9	73.6	506608.2	506608.2	100.0
Цагаандэлгэр	103778.0	89670.3	86.4	280883.6	280883.6	100.0
Баянжаргалан	193027.9	127179.3	65.9	305698.6	305698.6	100.0
Өндөршил	157564.5	118622.4	75.3	399307.6	399307.6	100.0
Гурвансайхан	174332.0	145057.7	83.2	542804.9	542804.9	100.0
Өлзийт	188692.8	154449.9	81.9	699692.8	699692.8	100.0
Хулд	216591.9	164238.8	75.8	678490.5	678490.5	100.0
Луус	180065.5	134123.1	74.5	561609.2	561609.2	100.0
Дэлгэрхангай	206023.3	165893.3	80.5	647382.1	647382.1	100.0
Сайхан-Овоо	147154.6	111993.5	76.1	519851.1	519851.1	100.0
Эрдэнэдалай	425581.3	316771.2	74.4	1669449.6	1669449.6	100.0
Сайнцагаан	191107.6	146221.0	76.5	718801.2	718801.2	100.0
Адаацаг	2957843.0	2823688.8	95.5	5190984.6	5190984.6	100.0
Дүн	5626063.0	4880341.2	86.7	13916583.0	13916583.0	100.0

VIII. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА /сая.төг/

2020.06.10

	2019 оны V сар	2020 оны V сар			<u>2020 V</u>
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	<u>2019 V</u> хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого		4881.4	16405.3	336.1	143.8
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	12436.4	4869.6	4140.8	85.0	33.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	606.1	397.8	674.3	169.5	111.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн	950.0	0.0	949.7	0.0	100.0
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	299.0	283.1	285.9	101.0	95.6
Ажилгүйдлийн даатгалын сангийн	119.7	63.5	221.1	348.2	184.7
Нийгмийн даатгалын сангийн зарлага		14453.1	14060.2	97.3	101.0
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	12027.1	11896.0	11669.9	98.1	97.0
Тэтгэмжийн даатгалын сангийн	523.7	723.2	653.7	90.4	124.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн	950.5	0.0	949.6	0.0	99.9
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	287.6	67.1	267.5	398.7	93.0
Ажилгүйдлийн даатгалын сангийн	132.7	250.7	150.9	60.2	113.7

Тайлбар: *Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

ХІ. НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭРИЙН ХЭМЖЭЭ

2020.06.10

Үзүүлэлтүүд	2018 оны V сар	2019 оны V сар	2020 оны V сар	$\frac{2020 \text{ V}}{2019 \text{ V}}$ хувь
Заавал даатгуулагчийн тоо	9229	9739	9225	94.7
Үүнээс:				
Аж ахуй нэгж, байгууллага	1904	1962	2014	102.7
Төсөвт байгууллага	3767	3779	3809	100.8
Сайн дурын	3558	3998	3402	85.1
Олгосон тэтгэвэр, сая.төг	10394.4	12025.6	13873.3	115.4
Үүнээс:				
Өндөр настны	8544.6	10055.9	11667.0	116.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн	1215.0	1255.4	1388.0	110.6
Тэжээгчээ алдсаны	314.0	327.1	376.0	114.9
Цэргийн	320.8	387.2	442.3	114.2

Х. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

2020.06.10

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		0-5 насны хүүхдийн эндэгдэл	
	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
Дэлгэрцогт	0	1	4	6	0	0	0	0
Дэрэн	1	2	2	5	0	0	0	0
Говь-Угтаал	2	5	0	2	0	0	0	0
Цагаандэлгэр	1	0	1	3	0	0	0	0
Баянжаргалан	0	1	3	1	0	0	0	0
Өндөршил	1	1	3	1	0	0	0	0
Гурвансайхан	0	0	1	10	0	0	0	0
Өлзийт	7	4	2	2	0	0	0	0
Хулд	0	1	6	6	0	0	0	0
Луус	3	0	5	1	0	0	0	0
Дэлгэрхангай	8	5	4	5	0	0	0	0
Сайхан-Овоо	3	1	8	9	0	0	0	1
Эрдэнэдалай	6	12	16	13	0	0	0	0
Сайнцагаан	342	357	39	27	0	2	0	3
Адаацаг	3	2	9	4	0	0	0	0
Дүн	377	392	103	95	0	2	0	4

ХІ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 5 сарын байдлаар

2020.06.10

Сумд	Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо		Бүгд үзлэг		Бүртгэгдсэн бүх өвчлөл		Халдварт өвчин бүгд		үүнээс /зарим үзүүлэлтээр/			
									сүрьеэ		салхинцэцэг	
	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020	2019	2020
Дц	149	161	945	817	148	164	3	5	0	1	1	0
Дн	74	99	932	1120	277	241	1	7	0	1	0	1
Гу	108	85	1857	1711	911	1053	5	5	0	0	2	2
Цд	68	84	660	493	90	305	0	4	0	0	0	4
Бж	118	71	859	820	107	87	1	3	0	0	1	1
Өш	145	125	1496	1549	93	228	1	3	0	0	0	0
Гс	100	60	1509	1919	303	126	4	3	1	0	0	0
Өт	69	95	1994	1618	165	118	8	3	2	1	1	0
Хд	98	110	784	463	389	215	9	2	1	0	1	0
Лс	107	56	1842	1282	80	103	2	6	1	0	0	2
Дх	90	82	1016	1079	47	40	3	3	1	1	0	0
Со	68	105	442	654	197	323	1	1	0	0	0	0
Эд	237	322	4816	4908	1114	969	9	10	1	1	0	1
Ад	149	142	2400	1714	180	336	8	8	1	2	4	0
Сц	2543	2208	56578	58324	10697	9552	136	68	3	7	95	13
Мд	199	194	179	190	0	0	0	0	0	0	0	0
Эб	245	197	204	235	0	0	0	0	0	0	0	0
МУЭ төв	393	375	879	1069	285	333	0	0	0	0	0	0
ДҮН	4960	4571	79392	79965	15083	14193	191	131	11	14	105	24

* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

XII. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

2020.06.10

	2020 V 2019 V	2020 V 2019 XII
ЕРӨНХИЙ ИНДЭКС	106.0	102.9
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	108.5	110.0
01.1 ХҮНСНИЙ БАРАА	109.2	110.7
01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА	119.5	107.5
01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН	103.6	132.3
01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН	102.2	96.3
01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ	96.8	91.7
01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС	115.4	109.0
01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ	108.9	100.0
01.1.7 ХҮНСНИЙ НОГОО	107.3	113.4
01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР	105.3	104.6
01.1.9 ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН	103.9	99.3
01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	99.5	101.0
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	103.3	102.9
02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА	102.2	101.8
02.2 ТАМХИ	104.9	104.5
03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ	109.3	102.6
03.1 ХУВЦАС, БӨС БАРАА	110.6	103.5
03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА	124.8	110.7
03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС	108.9	102.6
03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ	105.3	100.4
03.2 ГУТАЛ	106.4	100.6
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	107.8	100.4
04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС	100.0	100.0
04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	109.3	101.4
04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
04.5 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	100.0	100.0

Барааны бүлгээр		2020 V 2019 V	2020 V 2019 XII
05.	ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	105.6	102.4
	05.1 ГЭР АХУЙН ТАВИЛАГ, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	109.7	104.8
	05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	102.8	100.0
	05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	100.6	100.0
	05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	113.2	105.8
	05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭГ	100.1	102.0
	05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУСАД	102.9	100.3
06.	ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	102.9	102.4
	06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙНИ ХЭРЭГСЭЛ	103.4	102.8
	06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
	06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
07.	ТЭЭВЭР	96.7	96.8
	07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	100.0	100.0
	07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ	90.8	91.0
	07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	101.1	101.1
08.	ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
	08.2 ТЕЛЕФОН АППАРАТ, ФАКСЫН ХЭРЭГСЭЛ	100.0	100.0
	08.3 ТЕЛЕФОН УТАС, ФАКСЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
09.	АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	99.6	98.9
	09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМ	100.4	100.0
	09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.1	99.9
	09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	98.8	97.6
10.	БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	111.4	100.0
11.	ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	135.9	109.4
	11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	114.9	100.0
	11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	148.1	114.3
12.	БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	105.8	102.8
	12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	106.9	103.6
	12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	102.7	100.0
	12.5 ДААТГАЛ	100.0	100.0
	12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0

ХИИ. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 5-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ /аймгаар/

2020.06.10

	Нэр төрөл	Дундговь	Төв	Өмнөговь	Дорноговь
1	Гурил, дээд зэрэг /Алтантариа/	1783.0	1400.0	1730.0	1517.0
2	Гурил, 1-р зэрэг /Алтантариа/	1467.0	1200.0	1403.0	1183.0
3	Гурил, 2-р зэрэг /Алтантариа/	1050.0	900.0	1073.0	925.0
4	Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай	967.0	900.0	867.0	883.0
5	Талх, орон нутгийн үйлдвэрийн	1267.0	1300.0	1247.0	1567.0
6	Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/	1267.0	1300.0	2530.0	2067.0
7	Жигнэмэг /Юбилейные 150-180г, цайны/	1283.0	1300.0	1160.0	1283.0
8	Цагаан будаа, задгай, кг	2533.0	2600.0	2550.0	2500.0
9	Шар будаа, задгай, кг	3717.0	2900.0	3060.0	2433.0
10	Хонины мах, кг	8900.0	9500.0	8750.0	9500.0
11	Адууны мах, кг	-	9000.0	10000.0	9167.0
12	Ямааны мах, кг	7500.0	7500.0	7750.0	8333.0
13	Дотор мах, цувдай, цусгүй	5000.0	6000.0	2500.0	4500.0
14	Хиам чанасан, 1кг	10767.0	12572.0	5587.0	8500.0
15	Сүү, задгай, л	3000.0	1800.0	3500.0	2500.0
16	Сүү савласан,1л. Цэвэр сүү	3033.0	3046.0	3063.0	3000.0
17	Хорхой ааруул, задгай, чихэртэй	25000.0	15952.0	15000.0	15667.0
18	Өндөг,ш,дотоод	400.0	363.0	360.0	350.0
19	Ургамлын тос, 1литр, Кларина	4100.0	3950.0	3483.0	3317.0
20	Өөхөн тос, кг	-	1450.0	-	1500.0
21	Шар тос, кг	20000.0	25830.0	20000.0	18333.0
22	Цөцгийн тос, задгай, кг	3633.0	3800.0	3857.0	3700.0
23	Төмс дотоод, кг	1167.0	1066.0	1163.0	1167.0
24	Лууван хятад, кг	1650.0	2166.0	1400.0	2000.0
25	Байцаа хятад, кг	1750.0	2233.0	1200.0	2167.0
26	Сонгино хятад, кг	1617.0	1933.0	1600.0	1933.0
27	Элсэн чихэр, кг, орос	2000.0	2183.0	1933.0	2067.0
28	Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/	6500.0	5700.0	5993.0	5567.0
29	Зөөлөн чихэр, /Мишка/, кг	-	-	-	-
30	Шоколад, "Alpen gold"	2460.0	2530.0	2423.0	2300.0
31	Давс, цагаан, 1 кг, йоджуулсан	1133.0	996.0	1010.0	783.0
32	Майноз, /Золотой 500г/	2875.0	5333.0	2797.0	5450.0
33	Кетчуп, 900г, Чили Полиш	1967.0	1900.0	1900.0	2000.0
34	Ногоон цай, Stimo, савласан 90г	1633.0	1766.0	1647.0	-
35	Байхуу цай, Акбар, 20 ширхэгтэй	1625.0	1767.0	1590.0	1683.0
36	Цагаан архи, 0.5 Ерөөл	9033.0	9000.0	8563.0	9133.0
37	Пиво, "Боргио", 0.5л	1825.0	1836.0	1850.0	1825.0
38	Янжуур тамхи, /West/, саарал	3783.0	2800.0	3450.0	2700.0
39	Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи	2233.0	2063.0	2133.0	1900.0
40	Бензин, А-80, 1 литр	1490.0	1367.0	1487.0	1450.0
41	Бензин, А-92, 1 литр	1580.0	1383.0	1600.0	1500.0
42	Дизель түлш, 1 литр	2240.0	2067.0	2290.0	2253.0

XIV. ХАА-Н БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН МЭДЭЭ

2020.06.10

		Хэмжих нэгж	2019 оны 12 сар	2020 он				
				1 р сар	2 р сар	3 р сар	4 р сар	5 р сар
1. Малын үнэ /мян.төг/								
Тэмээ								
Нас гүйцсэн	эр	тол	1,100.0	1,238.5	1207.7	1155.6	1184.8	1223.3
	эм	тол	934.6	1,037.5	1020.8	1034.7	1051.7	1081.7
Өсвөр насны	эр	тол	653.8	720.8	736.4	740.9	716.7	736.7
	эм	тол	629.2	716.7	715.0	731.8	706.7	740.7
Адуу								
Нас гүйцсэн	эр	тол	857.1	942.9	921.4	933.3	924.4	913.9
	эм	тол	789.3	884.6	866.7	880.6	854.2	872.7
Өсвөр насны	эр	тол	611.5	650.0	645.0	671.7	630	630
	эм	тол	596.4	637.5	616.7	666.7	625	625
Үхэр								
Нас гүйцсэн	эр	тол	1,116.7	1,225.0	1233.3	1241.7	1250	1300
	эм	тол	903.6	1,070.8	1045.8	1113.6	983.3	1031.7
Өсвөр насны	эр	тол	725.0	750.0	771.4	722.2	644.4	635
	эм	тол	692.9	745.0	764.3	705.5	627.8	615
Бог мал								
Нас гүйцсэн хонь	эр	тол	152.0	164.6	167.7	176.4	176.6	191.9
	эм	тол	105.4	125.0	118.2	133.5	126.3	132.5
Нас гүйцсэн ямаа	эр	тол	128.0	132.3	132.9	135.6	131.6	133.1
	эм	тол	90.0	94.6	92.9	98.3	93.3	98.2
2. Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ /мян.төг/								
Тэмээний ноос	кг		0.0	0.0	0	0	0	0.0
Ямааны ноолуур	кг		85.0	-	65	65.0	45.0	45.0
Тэмээний шир	ш		-	18.0	22.0	-	-	-
Адууны шир	ш		10.0	8.0	8.0	5.0	-	5.0
-2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир	ш		8.0				-	
-2 м-ээс дээш хэмжээтэй үхрийн шир	ш		12.0	5.0	5.0		-	5.0
Хонины ноостой, олон гэдэстэй арьс	ш		2.0	2.0	2.0	1.0	1.0	1.0
Ямааны ноолууртай, өлөн арьс	ш		32.0	-	30.0	15.0	5.0	-

XV. ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ

2020-06-10

846	2019 оны мөн үед		2020 оны 5 сарын байдлаар														
	төлпөсөн хээлтэгч	бойжиж буй төл	төлпөсөн хээлтэгч	гарсан төл	бойжиж буй төл	Үүнээс					хорогдсон төл	Үүнээс					бойжилтын хувь
						Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг		Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг	
Сц	124106	124013	81214	81214	80569	577	556	164	44584	34688	645	11	6	2	144	482	99.2
Ад	102544	97727	64075	64075	60983	1170	841	123	30751	28098	3092	37	43	0	1152	1860	95.2
Бж	44704	44704	48506	48506	48506	891	710	24	28286	18595	0	0	0	0	0	0	100.0
Гу	64150	64048	61345	61388	59685	358	368	56	34797	24106	1703	31	11	4	695	962	97.2
Гс	82785	82785	93294	93299	93299	1834	1260	473	54132	35600	0	0	0	0	0	0	100.0
Дх	58371	59026	18079	18079	18079	491	192	605	7803	8988	0	0	0	0	0	0	100.0
Дц	56848	56454	34736	34736	33482	327	461	71	19765	12858	1254	9	10	0	460	775	96.4
Дн	101516	101832	94912	94912	94399	2070	1724	266	48258	42081	513	0	0	0	218	295	99.5
Лс	49639	49688	30396	30463	30198	140	339	93	16248	13378	48	0	0	5	20	23	99.1
Өл	101170	100880	71325	71325	70644	1356	540	2372	38371	28005	681	12	0	0	249	420	99.0
Өш	62868	62868	74248	74248	74248	2361	970	451	40214	30252	0	0	0	0	0	0	100.0
Со	74242	74092	59613	59613	59431	531	618	227	32879	25176	281	0	0	0	10	271	99.7
Хд	85060	85060	44791	44791	44791	818	592	1204	22567	19610	0	0	0	0	0	0	100.0
Цд	55484	55434	52527	52527	52234	541	384	104	29681	21524	293	0	2	2	115	174	99.4
Эд	175278	175204	110148	110148	110148	963	2101	195	54936	51953	0	0	0	0	0	0	100.0
Дүн	1238765	1233815	939209	939324	930696	14428	11656	6428	503272	394912	8510	100	72	13	3063	5262	99.1

XVI. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ (оны үнээр)

2020.06.10

МЯН.ТӨГ

Аж үйлдвэрийн салбар	2019	2020	2020/2019 хувь
Нийт дүн	4080883.1	3453133.5	84.6
Уул уурхайн олборлох аж үйлдвэр	1268975.0	236852.0	18.7
Нүүрс олборлолт	187369.0	194852.0	104.0
Гөлтгөнө	721106.0	0.0	-
Жонш олборлолт	360500.0	42000.0	11.7
Боловсруулах аж үйлдвэр	457552.8	549183.4	120.0
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	402589.2	373786.1	92.8
Хуснэгт маягт үйлдвэрлэл	7968.7	6195.3	77.7
Боловсруулах үйлдвэр бусад	46994.9	169202.0	360.0
Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	2354355.3	2667098.1	113.3
<i>Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл</i>	2056544.7	2399571.8	116.7
Ус ариутгал ус хангамж	297810.6	267526.3	89.8

XX. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

2020.6.10

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2019 оны мөн үед	2020 онд	2020/2019 хувь
Хүрэн нүүрс	мян.тн	6.6	6.9	104.5
Жонш	мян.тн	1.1	0.2	18.2
Гөлтгөнө	мян.тн	5.3	0.0	0.0
Дулааны эрчим хүч	мян.гкал	49.7	54.0	108.7
Хүснэгт, маягт	х.д.х	113.7	88.4	77.7
Талх	тн	55.1	55.5	100.7
Нарийн боов	тн	51.1	47.2	92.4
Чихэр	тн	1.4	2.1	150.0
Архи	мян.л	9.9	6.3	63.6
Хиамны зүйл	тн	0.5	1.0	200.0
Сүү, тараг	мян.л	4.5	0.3	6.7
Хоормог	мян.л	0.2	0.3	150.0
Ааруул	тн	0.5	0.2	40.0
Вакум цонх	м ²	0.0	0.0	-
Вакум хаалга	м ²	0.0	0.0	-
Модон эдлэл	мян.төг	43158.9	152942.0	354.4
Түгээсэн цэвэр ус	мян.т ³	55.5	48.6	87.6
Сувагжуулалт	мян.м ³	36.7	32.2	87.7
Оёдол эсгүүр	мян.төг	16370.0	12920.0	78.9
Блок	мян.ш	0.0	0.0	-

XVIII.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН МЭДЭЭ

2020 оны 06 сарын байдлаар мян.төг

2020.06.10

Халамжийн төрөл	Хамрагдсан хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн тэтгэвэр	777	856,846
Ахмад настны тэтгэвэр	47	45,993
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	519	540,218
16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр		-
Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд	211	270,635
Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэвэр		
Нийгмийн халамжийн тэтгэмж	1,726	626,382
<i>Асаргааны тэтгэмж</i>	35	424,071
<i>Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг</i>	28	14,118
<i>Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл</i>	4	2,674
<i>Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн</i>	3	1,242
<i>Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэний</i>	3	1,242
<i>Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэртээ асрамжилж байгаа иргэний</i>		
<i>Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан</i>	983	406,037
<i>Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг</i>	182	69,933
<i>Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа иргэнийг</i>	640	238,198
<i>Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг</i>	161	97,906
<i>Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай өрхийн гишүүн-иргэний</i>		
Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	708	202,311
<i>мөр(60)=мөр(61:66)</i>		
<i>Гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад</i>	5	6,000
<i>18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн</i>		
<i>Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй, нийгмийн</i>	1	1,200
<i>Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай,</i>		
<i>Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхэд</i>	166	162,951
<i>Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн</i>	536	32,160
Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж	4464	599,700
Хүүхдийн мөнгөн тэтгэмж		
Нийгмийн халамжийн үйлчилгээ		
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	3,051	147,920
<i>Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ</i>	3051	147,920
<i>Боловсролыг дэмжих үйлчилгээ</i>	0	-
Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт	126	18,085
Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	25	19,008
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	56	12,705
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	3389	192,654
<i>0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж</i>	2473	110711
<i>Жирэмсэн эхийн тэтгэмж</i>	772	17222
<i>Ихэр хүүхдийн тэтгэмж</i>	3	6,000
<i>Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн</i>	141	58,721
Насны хишиг	2495	223,650
Нийт	16,109	2,696,950

XIX. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-1

2020.06.10

Үзүүлэлт	2019 V	2020 V	20/19 хувь
Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо	30616	30183	98.6
Бүх хэрэг	102	105	102.9
Хүнийг санаатай алах гэмт хэрэг	0	0	0.0
Хүчиндэх гэмт хэрэг	2	3	0.0
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	4	1	0.0
Дээрэмдэх гэмт хэрэг	1	2	0.0
Хүрээлэн байгаа орчны эсрэг	1	11	0.0
Танхайн хэрэг	0	0	0.0
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	18	33	183.3
Бусдын эд хөрөнгийн хулгай	25	28	112.0
Малын хулгай	20	8	40.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг	11	5	45.5
Залилангийн хэрэг	13	8	61.5
Эдийн засгийн гэмт хэрэг	0	0	0.0
Бусад	7	6	85.7
Эмэгтэй хүн оролцсон	9	5	0.0
Согтуугаар	15	15	100.0
Бүлэглэж	5	11	220.0
Хүүхэд оролцсон	13	0	0.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	1	1	0.0
Хэргийн өнгө			
Хөнгөн	78	85	0.0
Хүнд	24	20	0.0
Хэргийн ангилал			
Гэмт хэрэгт холбогдогсод	50	65	130.0
Учирсан бүх хохирол /сая.төг/	286.5	247.0	86.2
Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/	78.6	114.9	0.0
Илрүүлэлтийн хувь	46.2	55.4	119.9
18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/	33	35	104.4

XIX. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-2

2020.06.10

№	Үзүүлэлтүүд		2019 V	2020 V	2020/2019 хувь
	Гэмт хэргийн улмаас		31	47	151.6
1	Нас барсан		4	3	75.0
	Гэмтсэн		27	44	163.0
	Зам тээврийн осолын улмаас		11	5	45.5
2	Нас барсан		1	2	200.0
	Гэмтсэн		10	3	30.0
	Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо		103	104	101.0
	Эмэгтэй		33	35	106.1
3	Үүнээс	7 хүртэлх насны	1	-	-
		8-13 насны	1	2	-
		14-17 насны	3	4	133.3
	Бүх хүлээн авсан өргөдөл, гомдол мэдээлэл		819	660	80.6
	Бүх шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй ӨГМ		295	252	85.4
	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн		138	138	100.0
	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан		141	95	67.4
4	Үүнээс	Харьяаллын дагуу шилжүүлсэн	2	2	100.0
		Үлдэгдэл	15	17	113.3
		Бүх шийдсэнээс 5 хоногт шийдвэрлэсэн	278	201	72.3
		6-ба түүнээс дээш	2	34	1700.0
	Бүх шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн шинжтэй ӨГМ-лэл		524	408	77.9
5	Шийдвэрлэсэн хугацаа	5 хоногт	422	328	77.7
		6 ба түүнээс дээш	80	64	80.0
		Үлдэгдэл	22	16	72.7
6	Нийт зөрчил		8312	7730	93.0
	ЗЦТасгаас илрүүлсэн		6424	5367	83.5
7	Торгуулийн арга хэмжээ авсан	НХЖХТасгаас илрүүлсэн	1638	2363	144.3
8	Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасч, торгосон		101	91	90.1
9	Баривчлагдсан хүн		40	37	92.5
10	Журамласан тээврийн хэрэгсэл		141	148	105.0
11	Эрүүлжүүлэгдсэн хүн		315	182	57.8
	Зөрчлийн хуулиар арга хэмжээ авагдсан	Хүний тоо	8175	7617	93.2
12		Мөнгөн дүн	297701.5	242235.0	81.4

XX.ГАМШГИЙН МЭДЭЭ

2020.06.10

Үйл ажиллагаа	2019 5-р сар	2020 5-р сар	20/19 хувь
Нийт ирсэн дуудлага	23	26	113.0
Аврах тусламж	0	3	-
Эрэн хайх	4	3	75.0
Газар хөдлөлт	0	3	-
Хүчтэй салхи шуурга	3	7	233.3
Мал амьтны гоц халдварт өвчин	1	6	600.0
Объектын гал түймрийн	6	5	83.3
Галын зөрчлийн	4	3	75.0
Орон нутгийн дуудлага	4	7	175.0
Дуудлагын үр дүн			
Аварсан хүн	8	13	162.5
Аварсан хөрөнгө /сая.төг/	312	170	54.5
Хохирол /сая.төг/	52.4	58.8	112.2
Иргэд ААН-д хандсан үйл ажиллагаа			
ААН-ийн хүсэлт	24	32	133.3
Иргэдийн өргөдөл	51	66	129.4
Хяналт шалгалт			
Хамрагдсан объект	43	48	111.6
Илэрсэн зөрчил	326	298	91.4
Газар дээр нь арилгасан	134	145	108.2
Албан шаардлага	27	21	77.8
Мэдэгдэл	25	29	116.0
Торгууль /сая.төг/		-	-
Шинжээчийн дүгнэлт	6	5	83.3

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

www.1212.mn



Дундговь аймгийн
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



www.dundgovi.nso.mn

Материалыг бэлтгэсэн:

Т.Бямбасүрэн
Г.Ариунжаргал
Г.Сайхантуяа

Утас 70593714, 70593715

2020 оны 06 сарын 10

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА

Б.ЭНХТУЯА